

УЛААНСАН ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Огноо: 2026 оны 4 сарын 29

Цаг: 14.00

Байршил: УБ хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Сүхбаатарын талбай 2, Сэнтрал тауэр 17 давхар

Хурлын дарга: П.Батбаяр

Хуралд оролцсон: Тооллогын комисс гишүүд, Хурал зохион байгуулах комисс, Хурлын дарга, гишүүд

Улаансан ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал (ХЭЭХ)-ыг 14.00 цагт нээв.

П.Батбаяр: Та бүхэнд энэ өдрийн мэндийг хүргэе. Компанийн ХЭЭХ-ыг үүгээр нээснийг мэдэгдэж байна. Өнөөдрийн хурлыг Батбаяр миний бие даргална. Өнөөдрийн хурлын ирцийн мэдээллийг тооллогын комиссоос танилцуулахыг хүсье.

Тооллогын комиссын дарга Ө.Бямбагэрэл: Улаансан ХК-ийн ХЭЭХ-ын ирцийн бүртгэлийг танилцуулья. Компанийн нийт гаргасан саналын эрхтэй 62,177 ширхэг хувьцаанаас 49,509 ширхэг буюу 79.6 хувийг эзэмшигч хувьцаа эзэмшигчид хуралд оролцсон буюу 79.6 хувийн ирцтэйгээр Компанийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсгийг үндэслэн хурал хүчин төгөлдөр болохыг мэдэгдье.

П.Батбаяр: Хурлын дэг болон хурлаар хэлэлцэх асуудлыг танилцуулав.

Хэлэлцэх асуудлын 1,2,3,5 дахь асуудлуудыг хурлын материалын хүрээнд танилцууллаа.

Компанийн жилийн санхүүгийн тайланд СЗХ-нд бүртгэлтэй ЦЭСБ Аудит ХХК аудит хийсэн. Аудитын зүгээс “Компани нь 2025 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын дагуу үнэн зөв толилуулж байна” гэж дүгнэсэн.

Хэлэлцэх асуудал 4: Компанийн жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлийг батлах. Компани нь 2025 онд Компанийн ТУЗ-ийг шинээр сонгох, компанийн дүрмийн өөрчлөлтийг бүртгүүлэх, засаглалын дүрэм журмуудаа шинэчлэн батлах, үргэлжлүүлэн үйл ажиллагаагаа сэргээн явуулах бэлтгэл ажлаа ханган ажиллалаа. Санхүүгийн байдлын хувьд Компани нь жилийн эцсийн байдлаар 19,667,300 төгрөгийн нийт хөрөнгөтэй, хуримтлагдсан алдагдал 104,686,700 төгрөг тус тус байна. Үйл ажиллагаа явуулаагүй тул орлого олоогүй. Санхүүгийн тайланд хараат бус аудит хийгдсэн ба аудитын дүгнэлтийг дээр танилцууллаа. Үйл ажиллагаа явуулаагүй тул орлого олоогүй. Компанийн ТУЗ-ийн зүгээс үйл ажиллагааны болон санхүүгийн тайланг хүлээн зөвшөөрч, холбогдох дүгнэлтийг баталсан.

Хэлэлцэх асуудал 6: ТУЗ-ийн 2026 оны төсвийг батлах. Компани үйл ажиллагаагаа идэвхжүүлж, явуулахаар бэлтгэл ажлыг ханган, компанийг уул уурхай, ашигт малтмалын

чиглэлийн аж ахуйн нэгжүүдэд хөрөнгө оруулалт хийх алсын хараатай ажиллаж байна. Компани нь хариуцлагатай уул уурхайн компаниудыг технологи, санхүүгийн хамгийн оновчтой шийдлээр дэмжих платформ гэж харж байгаа ба уул уурхайн компаниуд, орон нутгийн иргэд, санхүүжүүлэгч, зохицуулагчдыг нэгтгэж, уялдаа холбоотой ажиллах боломжийг бүрдүүлж ажиллахаар төлөвлөсөн. Иймд үйл ажиллагаа идэвхжэж орлого олох тохиолдолд ТУЗ-д төсвийн хүрээнд цалин урамшуулал олгохоор асуудлыг оруулж ирж байна.

Хэлэлцэх асуудал 7: Компанийн дүрэмд өөрчлөлт оруулах, батлах.

Компанийн оноосон нэрийг өөрчлөхтэй холбоотойгоор Компанийн дүрмийн 1.4 дэх хэсэгт заасан оноосон нэр Улаансан ХК-ийг Ард майнинг групп ХК болгон өөрчлөнө.

САНАЛ ХУРААЛТ

Тооллогын комисс:

Санал хураалтын дүнг үндэслэн тооллогын комиссын шийдвэрийг танилцуулав.

1. Компанийн 2025 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах тухай санал хураалтын дүн:
 - 1.1. Зөвшөөрсөн 49.509 ширхэг 100 хувь
 - 1.2. Татгалзсан, түдгэлзсэн санал байхгүй тул Компанийн тухай хуулийн 63.7 дахь хэсэгт заасны дагуу шийдвэр хүчинтэй.
2. ТУЗ-ийн 2026 оны төсвийг батлах тухай санал хураалтын дүн:
 - 2.1. Зөвшөөрсөн 49.509 ширхэг 100 хувь
 - 2.2. Татгалзсан, түдгэлзсэн санал байхгүй тул Компанийн тухай хуулийн 63.7 дахь хэсэгт заасны дагуу шийдвэр хүчинтэй.
3. Компанийн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах, батлах тухай санал хураалтын дүн:
 - 3.1. Зөвшөөрсөн 49.509 ширхэг 100 хувь
 - 3.2. Татгалзсан, түдгэлзсэн санал байхгүй тул Компанийн тухай хуулийн 63.7 дахь хэсэгт заасны дагуу шийдвэр хүчинтэй.

П.Батбаяр: Тооллогын комиссын шийдвэрийг танилцуулсан тул 2026 оны 4 сарын 29-ний өдрийн ХЭЭХ-аас гарсан шийдвэрүүдийг танилцуулья.

Дараах шийдвэрүүдийг уншиж танилцуулав. 1. Компанийн 2025 оны жилийн үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батласугай. 2. ТУЗ-ийн 2026 оны төсвийг батласугай. 3. Компанийн оноосон нэр “Ард майнинг групп”, англиар “Ard mining group” болон өөрчлөгдсөнтэй холбогдуулан Компанийн дүрмийн 1.4 дэх хэсгийг өөрчлөж, дүрмийн өөрчлөлтийг баталсугай.

ХУРЛЫН ХААЛТ

Үүгээр өнөөдрийн хурлын хаасныг мэдэгдье.

ХЯНАСАН:

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:



ХУРЛЫН ДАРГА П.БАТБАЯР

Ө.АШХҮҮ